

## ДУНДГОВЬ АЙМГИЙН САЙНЦАГААН СУМЫН УЛСЫН ТЭРГҮҮНИЙ 3-Р ЦЭЦЭРЛЭГИЙН ТАНИЛЦУУЛГА

### МАНАЙ ЦЭЦЭРЛЭГИЙН АЛСЫН ХАРАА

Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээгээр манлайлж, чанар, сэтгэл ханамжийг эрхэмлэн дээдэлдэг, олон нийтэд үнэлэгдэхүйц байгууллага болно.

### МАНАЙ ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО

“Бага насны хүүхдийг асрах, хамгаалах, хүмүүжүүлэх, сургах цогц үйл ажиллагаагаар хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих, сургуульд амжилттай бэлтгэхэд бидний эрхэм зорилго оршино “


### МАНАЙ ЦЭЦЭРЛЭГИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

- ✓ Хүүхэд бүрийн хөгжилд цогц хандан тэднийг хайрлан хүндэлж, танин мэдэхүйн онцлог дээр нь тулгуурлан хөгжүүлнэ.
- ✓ Хүүхэд бүрийн хүсэл сонирхол, сонголтыг хүндэтгэж , өөртөө итгэлтэй байдлыг нь дэмжинэ.
- ✓ Хүүхдийн хувийн зан чанарын онцлогийг харгалзаж өөрийнх нь хүчийг мэдрүүлнэ.

### ТҮҮХЭН ХӨГЖЛИЙН ЗАМ

Тус цэцэрлэг нь анх 1968 онд 2 бүлэг ,50 хүүхэдтэй 8 ажилчинтайгаар байгуулагдсан ба түүнээс хойш сургуулийн өмнөх насны хүүхдэд СӨБ олгох үйл ажиллагааг үе үеийн багш ажилчдын хөдөлмөр үйл ажиллагаагаар одоог хүртэл хүргэн ажиллаж байна . Тус цэцэрлэг нь 1985 оноос 160 хүүхдийн хүчин чадалтай зориулалтын барилгад шилжин орж ажилласнаар СӨН-ны хүүхдийг хамран сургах хүрээ хүртээмж нэмэгдэн СӨНХ-дэд СӨБ олгох үйл ажиллагааны хөгжил ,сургалтын арга зүйн агуулга ,багш ажилчдын боловсролын түвшин хөдөлмөрийн чадавхи жилээс жилд дээшлэн ажлын туршлага арга барил , мэргэжлийн ур чадвар ,мэдлэг дадлага хуримтлуулан Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, ,Боловсролын тухай багц хууль, Сургуулийн өмнөх боловсролын хууль, ,Төрийн албаны тухай хууль, Аймаг орон нутгийн боловсролыг хөгжүүлэх тухай бодлого болон бусад холбогдох хууль тогтоомжинд нийцүүлэн сургалт үйл ажиллагаагаа төлөвлөн ажиллаж байна .

### ХАМРАН СУРГАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТ /сүүлийн 10 жилээр /



## ХҮНИЙ НӨӨЦ

- Цэцэрлэгийн бүтэц бүрэлдэхүүн нийт 28.5 ажиллагсадтай үүнээс эрхлэгч 1, арга зүйч 1, ня-бо 1, багш 8, туслах багш 7, нярав 1, тогооч 3, үйлчлэгч 1, угаагч 1, жижүүр 4, эмч 0,5 гэрээгээр ажилладаг.
- Нийт багш нар 100% нь бакалавр, магистрын боловсролтой
- Эрхлэгч Зөвлөх зэрэгтэй, нийт багш нарын 75% нь мэргэжлийн зөвлөх ,тэргүүлэх ,заах аргач зэрэгтэй
- Туслах багш нар 100% сургалтанд хамрагдсан
- Туслах багш нарын 28,5% нь дээд боловсролтой , 71,5% нь бүрэн дунд боловсролтой
- Тогооч нярав 100 % мэргэжлийн

## ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ГОЛ ЧИГЛЭЛҮҮД

1. Чанартай сургалт, чадварлаг багш
2. Хүртээмжтэй үйлчилгээ, халамжтай эцэг эх
3. Эрүүл биед саруул ухаан
4. Ээлтэй орчин, эрх зүйт хандлага
5. Нийгмийн түншлэл, үр ашигтай менежмент
6. Гэр бүлийн оролцоо, шүтэлцээт хариуцлага

## ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМУУД

- ✓ Сургалт хөгжүүлэх ажлын чанарыг сайжруулж, арга зүйг хөгжүүлэхийн тулд багшийн тасралтгүй хөгжлийг хангана.
- ✓ СӨБ-ын хамран сургалтын хүртээмжийг нэмэгдүүлж тойргийн хүүхдийг 100% хамрахын тулд ердийн болон хувилбарт сургалтуудыг хэрэгжүүлж, СӨНХ-ийг цэцэрлэгт хамруулах ажилд эцэг эхийн халамж анхаарал оролцоог нэмэгдүүлнэ .
- ✓ Багш ажиллагсадын болон хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах талаар анхаарч жил бүр эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулан орон тооны эмч ажиллуулж, хүүхдийг өвчлөлөөс сэргийлэх ажлыг өргөн хүрээгээр зохион байгуулна.
- ✓ Хүүхдэд ээлтэй, тэдний хэрэгцээ сонирхлыг хангасан стандартын шаардлагад нийцсэн орчинг бүрдүүлж, хүүхдийн эрхийг зөрчихгүй байхад анхааран ажиллана.
- ✓ СӨБ-ын хөгжилд төрийн болон төрийн бус байгууллага, иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж үр ашигтай, чанартай олон хувилбартай үйл ажиллагааг нэвтрүүлнэ.
- ✓ Эцэг эх гэр бүлийн гишүүдийн оролцоог хангаж тэдний үүрэг хариуцлагыг ухамсаруулах сургалт сурталчилгаа, сонирхолтой олон хувилбартай ажлуудыг зохион байгуулна.
- ✓ Боловсролд тэгш хамран сургахыг дэмжиж төсөл хөтөлбөр хэрэгжүүлнэ.